



МОНГОЛ УЛСЫН ЕРӨНХИЙ САЙДЫН 2017 ОНЫ “САХИЛГА ХАРИУЦЛАГА, ДЭГ ЖУРМЫГ ЧАНГАТГАХ ТУХАЙ” 01 ДҮГЭЭР АЛБАН  
ДААЛГАВАР БОЛОН ЗАСГИЙН ГАЗРЫН 2018 ОНЫ “ТӨРИЙН АЛБАНЫ САХИЛГА ХАРИУЦЛАГА, ДЭГ ЖУРМЫГ ЧАНГАТГАХ  
ТУХАЙ” 258 ДУГААР ТОГТООЛЫГ 2018-2020 ОНД ХЭРЭГЖҮҮЛЭХ АЖЛЫН ТӨЛӨВЛӨГӨӨ 87 СБТ9512

2018 оны 08 дугаар сарын 28-ны өдөр

Д/Д	Хэрэгжүүлэх үйл ажиллагаа	Хугацаа	Хариуцах газар, хэлтэс	Тайлбар
<b>1.1 Иргэндээ ээлтэй хуулийн засаглалыг бэхжүүлэх: Төрийн бүх шатны байгууллагын албан хаагчид шударга ёс, хууль дээдлэх зарчим баримтлан, төрийн албан хаагчийн ёс зүйн хэм хэмжээг чанд сахиж, улс төрөөс ангид, мэргэжлийн өндөр мэдлэг, ур чадвартай ажиллах хүрээнд:</b>				
1.	ЗТХ-ийн сайд болон ЗТХЯ-ны Төрийн нарийн бичгийн даргаар “Хууль-эрх зүй” сэдэвт сургалтын төлөвлөгөөг батлуулж, сургалт зохион байгуулах	Тухай бүр	ТЗУГ	
	Төрийн албаны соёл, дэг журмыг сахиулах, ажлын цаг ашиглалт, ажлын бүтээмжийг дээшлүүлэх зорилгоор гэнэтийн болон төлөвлөгөөт хяналт шалгалтыг яам болон харьяа байгууллагууд дээр зохион байгуулах	Тухай бүр	ТЗУГ, ХШУДАГ	
	Ажлын байран дахь бүх хэлбэрийн хууль бус дарамт шахалт, ялгавартай хандах үйлдлийг таслан зогсоож, ийм үйлдэл гаргасан албан тушаалтанд хүлээлгэх хариуцлагын талаар байгууллагын дотоод журамд тусгаж, зэрэг уур амьсгалтай, сэтгэл зүйн дарамтгүй ажиллах орчныг бүрдүүлэх талаар арга хэмжээ авч ажиллах	2018 онд	ТЗУГ	
	Төрийн албан хаагчид Төрийн албаны тухай” хуулийн 13 дугаар зүйлийн 13.1.5-д “төрийн албаны болон төрийн албан хаагчийн ёс зүйн хэм хэмжээ, төрийн байгууллагын соёл, дэг журмыг сахиж, төрийн байгууллага, албан хаагчийн нэр хүндийг эрхэмлэн дээдлэх” үүргээ биелүүлж байгаа байдалд явцын шалгалт хийж ажиллах	2018-2019 онд	ТЗУГ ХШУДАГ	
2.	Монгол Улсын Засгийн газрын 2010 оны 288 дугаар тогтоолоор батлагдсан “Төрийн захиргааны албан хаагчийн ёс зүйн дүрэм”-ийг Зам, тээврийн хөгжлийн яамны цахим хуудсанд байршуулж, сурталчлан таниулах сургалт сурталчилгаа зохион байгуулж ажиллах	2018-2020 онд	ТЗУГ	
3.	Төрийн жинхэнэ албан хаагчийн сул орон тоо гарсан тохиолдолд уг орон тоон дээр нээлттэй сонгон шалгаруулалт зарлаж, ЗТХЯ-ны цахим хуудсанд ил тодоор байршуулах	Тухай бүр	ТЗУГ	
	Төрийн жинхэнэ албан хаагчийн сул орон тоог нөхөхдөө мэргэшлийн шалгалт өгсөн, төрийн албаны нөөцөд бүртгэлтэй иргэнийг сонгон шалгаруулах ажлыг хуулийн дагуу зохион байгуулж, ЗТХЯ-ны цахим хуудсанд байршуулж хэвших	Тухай бүр	ТЗУГ	
4.	Төрийн албаны тухай хуулийг /шинэчилсэн найруулга/ хэрэгжүүлэх үүрэг бүхий Ажлын хэсгийг ЗТХЯ-ны Төрийн нарийн бичгийн даргын тушаалаар байгуулж, бэлтгэл ажлыг хангах арга хэмжээ авах	2018 онд	ТЗУГ	
5.	Зам, тээврийн хөгжлийн яамны албан хаагчдад “Байгууллагын соёл төлөвшүүлэх” тухай сургалт зохион байгуулах	Хуваарийн дагуу	ТЗУГ	
<b>1.2 Авилгын хяналтыг сайжруулах: Төрийн албыг хувийн ашиг сонирхлын хэрэгсэл болгох гэсэн оролдогыг тухай бүр нь таслан зогсоож, авилга, хээл хахууль, хүнд суртал, шударга бус байдалтай шат шатандаа тэмцэх хүрээнд:</b>				
6.	Авилгын эсрэг үйл ажиллагааны төлөвлөгөө батлуулж, хэрэгжилтийг хангаж ажиллах	2018-2020 онд	ТЗУГ	

			Бусад газар, хэлтэс	
7.	Нийтийн албанд томилогдохоор нэр дэвшсэн этгээдийн хувийн ашиг сонирхлын урьдчилсан мэдүүлгийг АТГ-т хянуулсны дараа томилогдох үйл ажиллагааг мөрдөн ажиллах	Тухай бүр	ТЗУГ	
8.	"Хууль-эрх зүй" сэдэвт сургалтын төлөвлөгөөнд Авилгын эсрэг хууль болон Гэмт хэргээс урьдчилан сэргийлэх тухай хуулийг хэрэгжүүлэх талаар тусгай хэсгийг нэмж оруулах	2018-2019 он	ТЗУГ	
9.	Нийтийн албанд томилогдохоор нэр дэвшсэн этгээдийн хувийг ашиг сонирхлын урьдчилсан мэдүүлгийг 2017-2019 онд Авилгатай тэмцэх газарт хянуулсан байдалд үнэлгээ хийх	2018-2019 он	ХШУДАГ	
10.	Албан тушаалд томилогдсон албан хаагчдын хөрөнгө орлогын мэдүүлгийг 30 хоногийн дотор гаргаж хэвшүүлэх, хөрөнгө орлогын мэдүүлгээ хугацаа хожимдуулж гаргасан, худал мэдүүлсэн албан хаагчид хариуцлага тооцох	2018-2020 он	ТЗУГ	
11.	Зам, тээврийн хөгжлийн яамны газар хэлтсүүд Авилгын эсрэг хуулийн 6 дугаар зүйлийн 6.1-д заасан үүргээ хэрэгжүүлж буй байдалд шалгалт хийх	2018-2020 он	ТЗУГ ХШУДАГ	
12.	Авилгын эсрэг хууль тогтоомжид заасан авилгаас урьдчилан сэргийлэх, соён гэгээрүүлэх ажлыг зохион байгуулж, авилгад өртөж болзошгүй ажлын байрны жагсаалтыг гаргаж Зам, тээврийн хөгжлийн яамны цахим хуудсанд байршуулж, ашиг сонирхлын зөрчил үүсэхгүй байх нөхцөлийг бүрдүүлж ажиллах	2018-2020 он	ТЗУГ, бусад газар хэлтсүүд	
13.	Авилгын эсрэг үйл ажиллагааны талаар байгууллагын цахим хуудсанд мэдээлэл тогтмол байршуулах	Тухай бүр	ТЗУГ, бусад газар хэлтсүүд	
<b>1.3 Иргэдээ сонсож, төрийн албаны хариуцлагыг өндөржүүлэх: "Засгийн газрын иргэд олон нийттэй харилцах төв"-д иргэдээс ирүүлсэн өргөдөл, гомдлыг шуурхай нягтлан шалгаж, асуудлыг шийдвэрлэн дутагдал гаргасан холбогдох албан тушаалтанд тухай бүр хариуцлага тооцож ажиллах:</b>				
14.	Иргэдээс төрийн байгууллага албан тушаалтанд гаргасан өргөдөл гомдлын шийдвэрлэлтэд байнга хяналт тавьж, мэдээллийг байгууллагын цахим хуудсанд байршуулж ажиллах	Тухай бүр	ТЗУГ	
15.	Иргэдээс ирүүлсэн өргөдөл, гомдлын талаархи нэгдсэн мэдээллийг Сайдын зөвлөлийн хуралд хагас бүтэн жилээр нэгтгэн танилцуулж байх	2018-2020 он	ТЗУГ	
16.	Иргэдээс төрийн байгууллага, албан тушаалтанд гаргасан өргөдөл, гомдлын агуулгад дүгнэлт хийж, өргөдөл, гомдол шийдвэрлэлтийн хугацаа хэтрүүлсэн, хариуцлагагүй хандсан албан хаагчид хариуцлага тооцож ажиллах, дотоод журамд заалт нэмж оруулах	2018 он	ТЗУГ	
<b>2.1 Албан тушаалтны сахилга, хариуцлагыг өндөржүүлж, аливаа ажил, асуудлыг цаг алдалгүй шуурхай зохион байгуулж гүйцэтгэлийн үр дүнд тавих хяналтыг сайжруулан хүлээлгэх хариуцлагыг чангатгаж, төрийн албаны стандартыг мөрдүүлж ажиллах хүрээнд:</b>				
17.	Албан хаагчдын цаг ашиглалтын байдалд хяналт тавьж, цаг ашиглалтын мэдээг 7 хоног бүр мэдээлж ажиллах, хагас бүтэн жилээр нэгтгэсэн товчоо гаргаж, ажлын үр дүнг дүгнэхэд харгалзан үзэх	2018-2020 он	ТЗУГ, бусад газар хэлтсүүд	
18.	Албан хаагчдын ажлын байрны шинжилгээ хийж, шинжилгээний дүнд тулгуурлан байгууллагын чиг үүргийн давхардал, хийдлийг арилгаж, ажлын бүтээмж, үйл ажиллагааны уялдаа холбоог сайжруулах чиглэлээр ажлын хэсэг байгуулж ажиллах	2018 он	ТЗУГ, БТГ, газар хэлтсүүд	
19.	Ажил таслах, хоцрох, эрт тарах зэрэг асуудлыг таслан зогсоож, зөрчил гаргасан албан хаагчид хариуцлага тооцох заалтыг Хөдөлмөрийн дотоод журамд шинэчлэн оруулж мөрдөх	2018 он	ТЗУГ	
20.	Яамны сургалт, сурталчилгааны ажлын төлөвлөгөө төлөвлөгөөний дагуу сургалтыг зохион байгуулсан байдалд дүн шинжилгээ хийж ажиллах, төрийн албан хаагчдыг багц сургалтад хамруулах	2019-2020 он	ТЗУГ	
21.	Төрийн хяналт шалгалт болон яамны хяналт шалгалтын явцад илэрсэн зөрчил дутагдлыг шуурхай арилгах арга хэмжээ авч, буруутай удирдах албан тушаалтан, албан хаагчид тухай бүр хариуцлага тооцож ажиллах	2018-2020 он	ТЗУГ, бусад газар хэлтсүүд	
<b>2.2 Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил үйлчилгээ худалдан авах, хууль тогтоомжид заасан лизенц болон бусад тусгай зөвшөөрөл, газар олгох ажлыг нийтэд ил тод, нээлттэй болгон зохион байгуулж ажиллах хүрээнд:</b>				
22.	Худалдан авах ажиллагаа болон тусгай зөвшөөрөл олгохтой холбоотой мэдээллийг ил тод			

	нээлттэй болгож байгууллагын цахим хуудсанд тогтмол байршуулж байх	Тухай бүр	БТГ	
23.	Мэдээллийн ил тод байдал ба мэдээлэл авах эрхийн тухай хууль болон Шилэн дансны тухай хуулийг хэрэгжүүлж буй ЗТХЯ-ны үйл ажиллагаанд үнэлгээ дүгнэлт өгөх	Тухай бүр	ХШУДАГ	
24.	Тусгай зөвшөөрөл олгох ажиллагааг нээлттэй ил тод байлгах зорилгоор цахим системд холбох ажлыг судлах, Зөвшөөрлийн тухай хуулийн төсөлд санал бэлтгэн хүргүүлэх	2018-2020 он	ТЗУГ, БТГ бусад газар хэлтсүүд	
<b>2.3 Төрийн албаны тухай хууль тогтоомж, дүрэм, журмыг хэрэгжүүлж, төрийн байгууллагын ил тод, нээлттэй байдлыг хангах тухай бүр нь хариуцлага тооцож, зохих байгууллага, албан тушаалтанд мэдээлж байх хүрээнд:</b>				
25.	Нийт албан хаагчдын анкетын судалгааг цахим хэлбэрт шилжүүлж албан хэрэгцээнд ашиглах боломжийг бий болгох	2018-2019 он	ТЗУГ, бусад газар хэлтсүүд	
26.	Төрийн үйлчилгээг иргэдэд хүнд сурталгүй, чирэгдэлгүй, ээлтэй үйлчилгээ үзүүлж ажиллах зорилгоор "Угтах үйлчилгээ"-г нэвтрүүлж, үйл ажиллагааг нь стандартчилж, шинэ хэлбэр агуулгаар баяжуулах	2018 он	ТЗУГ	
27.	Ажлын үр дүн, хөдөлмөр зохион байгуулалт, бүтээлч ажилтай холбогдуулан албан хаагчдын гаргасан санал, санаачлагыг байгууллагын удирдлагаас дэмжиж ажиллах механизмыг бүрдүүлж, байгууллагын соёлыг төлөвшүүлэх чиглэлээр тодорхой ажлуудыг хийх	2018-2020 он	ТЗУГ, бусад газар хэлтсүүд	
<b>2.4 Хууль тогтоомж зөрчсөн, зөрчил, дутагдал гаргасан, ажлаа цалгардуулсан албан тушаалтанд холбогдох хуулийн дагуу тухай бүр нь хариуцлага тооцож, зохих байгууллага, албан тушаалтанд мэдээлж байх ажлын хүрээнд:</b>				
28.	Хөдөлмөрийн дотоод журам болон Ёс зүйн дүрэмд ажлын хариуцлага алдсан, ёс зүйн зөрчил гаргасан албан хаагчид хариуцлага ногдуулах тухай заалтыг тусган нэмэлт өөрчлөлт оруулах	2018-2019 он	ТЗУГ	
29.	Харьяа байгууллага болон салбар, нэгжид сахилга, дэг журмыг сахиулах тодорхой арга хэмжээ авч, төрийн албаны хууль тогтоомж, холбогдох дүрэм, журмыг зөрчсөн албан хаагчдад хариуцлага тооцож, тухай бүр тайлагнаж ажиллах	2018-2019 он	ТЗУГ	
30.	Албан хаагч албан томилолтын явцад, ажлын болон ажлын бус цагаар ажлын байранд согтууруулах ундаа хэрэглэх явдлыг таслан зогсоох, төрийн байгууллагын байр, ажлын байранд согтууруулах ундаа, мансууруулах бодис, галт болон хүйтэн зэвсэг, тэсэрч дэлбэрэх болон шатамхай бодис хэрэгслийг нэвтрүүлэх, хадгалах, хэрэглэх, ашиглахыг хориглож, зөрчсөн тохиолдолд хариуцлага тооцох тухай заалтыг Хөдөлмөрийн дотоод журамд тусгаж мөрдөх	2018 он	ТЗУГ	
31.	Албан хаагчдын үйлдсэн гэмт хэрэг, гаргасан зөрчил, сахилга, ёс зүйн зөрчилд судалгаа, дүн шинжилгээ хийж, шалтгаан нөхцөлийг тогтоон, урьдчилан сэргийлэх арга хэмжээг үр дүнтэй зохион байгуулах	2018-2020 он	ТЗУГ	
32.	Ажлын цаг ашиглалтыг хурууны хээний болон камерын хяналтын системээр байнга бүртгэж, түүнд тавих хяналтыг сайжруулах, хариуцлагын талаар Хөдөлмөрийн дотоод журамд нэмэлт өөрчлөлт оруулах	2018 он	ТЗУГ	
<b>2.5 Удирдлага, ажилтнуудын үр дүнгийн болон хөдөлмөрийн гэрээг хагас, бүтэн жилээр дүгнэж, гүйцэтгэлийн үр дүнг урамшуулал, хариуцлагатай холбож ажиллах хүрээнд:</b>				
33.	Удирдлага ажилтнуудын үр дүнгийн болон хөдөлмөрийн гэрээг хагас бүтэн жилээр дүгнэж, гүйцэтгэлийн үр дүнг урамшуулал, хариуцлагатай холбож ажиллах	2018-2020 он	ТЗУГ, бусад газар, хэлтсүүд	
34.	Албан хаагчдын үр дүнгийн гэрээний биелэлтийн үнэлгээнд албан хаагчийн ёс зүй, ажлын цаг ашиглалт, идэвх санаачлага, ажлын төлөвлөлт, үүрэг даалгаврын биелэлт, олон нийтийн арга хэмжээнд оролцсон байдал зэрэг шалгуурыг харгалзан үзэх	2018 он	ТЗУГ	
35.	Албан хаагчдын үйл ажиллагааны төлөвлөлт, үр дүнгийн гэрээний биелэлт, ажлын үр дүнд жил бүр хяналт-шинжилгээ хийж, санал зөвлөмж гарган холбогдох арга хэмжээг авч ажиллах	2018-2020 он	ХШУДАГ, бусад газар хэлтсүүд	
36.	Яамны нэгжүүдийн болон харьяа байгууллагуудын үйл ажиллагаанд улирал тутам хяналт-шинжилгээ хийж, үр дүнгийн үнэлгээг үндэслэн урамшуулах, хариуцлага тооцох асуудлыг тухай бүр шийдвэрлэж байх	Тухай бүр	ТЗУГ ХШУДАГ	
<b>3.Төсвийн хөрөнгө оруулалтын ажлын чанар, үр дүнг дээшлүүлж төсвийн үргүй зардлыг багасган хөрөнгийг зориулалтын дагуу үр ашигтай зарцуулж, хэмнэлтийн горимыг чанд сахин ажиллах хүрээнд:</b>				
37.	Төсвийн хөрөнгөөр хэрэгжүүлж байгаа төсөл, хөтөлбөрийн хэрэгжилтийн байдалд хяналт	2018-2019 он	ХШУДАГ	

	тавьж явцын болон гүйцэтгэлийн тайлан мэдээг танилцуулж байх			
38.	Яамны дотоод аудитын нэгжээс яам, харьяа байгууллагын төсвийн хөрөнгийн зарцуулалт, үр ашигт хяналт шалгалт хийж, хөрөнгийг зориулалт бусаар, үр ашиггүй зарцуулсан холбогдох албан тушаалтан, шийдвэр гаргагчдад хариуцлага ногдуулах саналыг тавьж шийдвэрлүүлж байх	Тухай бүр	ТЗУГ ХШУДАГ	
39.	Ажлын хариуцлага сахилга батыг сайжруулах чиглэлээр гарсан Засгийн газрын болон Зам, тээврийн хөгжлийн сайдын албан даалгавар, төлөвлөгөөнд туссан ажлын хэрэгжилтийн тайланг хагас, бүтэн жилээр гаргаж ирүүлж байх	2018-2020 он	ТЗУГ бусад газар хэлтсүүд	

---oOo---